

КОМПАНИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

1. **Компанийн бизнесийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл:** “Хөнгөн Бетон” ХК нь түрээс болон дэд бүтцээ ашиглуулах үйл ажиллагаа явуулж байна. Энэхүү орлогоороо өр төлбөрөө барагдуулахад хүндрэлтэй байна.
2. **Санхүүгийн байдлын талаарх мэдээлэл:** Компани 2024 онд 3,817,800,000 төгрөгийн орлого олсон ба борлуулалтын орлогыг хөрөнгийн түрээс болон компанийн үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулснаас олсон байна. 2024 онд компанийн нийт актив хөрөнгө 1.9 тэрбум төгрөг, нийт өр төлбөр 6.2 тэрбум төгрөг байгаа ба өр төлбөрийн хэмжээ их байгаа нь компанийн үйл ажиллагаа хэвийн явуулахад хүндрэл учруулж байна. Банкны өр төлбөр одоогоор оны эцсийн байдлаар 1,6 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна. Мөн Шүүхийн Шийдвэр, Татвар, Нийгмийн даатгал, харилцагч нарт их хэмжээний өр төлбөртэй байна. Эдгээр нь санхүүгийн тайланд тусгагдсан байгаа.

3. Хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээлэл

“Хөнгөн бетон” ХК-ийн нийт гаргасан хувьцааны тоо 179,373 ширхэг. 2025 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төвөөс ирүүлсэн 5 ба түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигчдийн хувь эзэмшлийн судалгаагаар дараах байдлаар хувьцаа эзэмшиж байна.

Д/д	Хувьцаа эзэмшигчдийн нэрс	Тоо ширхэг	Хувь
1	Б.Наранзул	130,958	73,01%
2	Б.Наранцацралт	30,244	16,86%
3	“Минжит булган гол” ХХК	14,918	8,32%
4	Т.Баярхүү /өв залгамжлагч Б.Наранзул, Б Наранцацралт/	1,034	0,58%
		177,154	98,76%

4. Ногдол ашигийн талаарх мэдээлэл

- 1) “Хөнгөн бетон” ХК болон “Хас банк” ХХК-ийн хооронд 2012 оны 11-р сард байгуулагдсан “Хугацаат зээлийн гэрээ”-ний “Зээлдэгч нь аливаа ногдол ашиг зарлахгүй, олгохгүй” тухай “Хавсралт 3 В.1” дүгээр заалтыг үндэслэн ногдол ашиг олгохгүй байгаа.
- 2) “Хөнгөн бетон” ХК нь банкны өмнө хүлээсэн үүргийн дагуу ногдол ашиг хуваарилах боломжгүй.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Б.НАРАНЗУЛ